



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 27 өдөр


Дугаар А/405

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гүйцэтгэгчээр шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах эрхийг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д шилжүүлсүгэй.
2. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Дөлбадрал), ашиглагч байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д даалгасугай.
4. Хууль тогтоомжийн дагуу холбогдох гэрээ, бүрдүүлэх материалыг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.
6. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/615 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2057